



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын Их Хурлын <http://parliament.mn/c/pwyo> цахим хаяг эсхүл дээрх QR кодыг ашиглан бусад танилцуулга, мэдээтэй танилцана уу.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

АГУУЛГА

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2023 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ 3-4

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ	5
1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:	5
1.2. Бодит ДНБ-ий өсөлт ба нэг хүнд ногдох ДНБ:	10
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ	11
2.1. Нэгдсэн төсвийн орлого:	11
2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага:	15
ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА	16
3.1. Гадаад худалдааны эргэлт:	16
3.2. Экспорт:	18
3.3. Импорт:	22
ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	24
4.1. Мөнгөний нийлүүлэлт:	24
4.2. Гадаад валютын албан нөөц:	27
4.3. Төлбөрийн тэнцэл:	28
ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ	29
5.1. Хүн ам, ажил эрхлэлт:	29
5.2. Ажилгүйдэл:	29

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ



Эдийн засаг 7.9 хувиар өсжээ. 2022 оны эхний улирлын байдлаар эдийн засгийн өсөлт -3.9 хувьтай гарч байсан бол 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр 7.9 хувьд хүрч, эдийн засаг 11.8 нэгж хувиар өссөн байна. Эдийн засаг 11.8 нэгж хувиар өсөхөд өмнөх оны мөн үеийн өсөлтөөс хөдөө аж ахуйн салбар 0.7 нэгж хувиар буурсан хэдий ч уул уурхай 11.4 нэгж хувь, аж үйлдвэр, барилга 0.7 нэгж хувь, тээвэр ба агуулахын үйлчилгээ 3.5 нэгж хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал буурсан. 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт дүн 4,794.8 тэрбум төгрөг, төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн дүн 4,138.2 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 656.6 тэрбум төгрөгийн ашигтай гарч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн алдагдал өмнөх оны мөн үеэс 911.3 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдлын ДНБ-д эзлэх хэмжээ 4.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 7.5 нэгж хувиар өссөн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээ 911.3 тэрбум төгрөгөөр өсөж, 656.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсантай холбоотой байна.

Төсвийн орлогын хувьд: Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр 4,794.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1,226.8 тэрбум төгрөгөөр илүү төвлөрсөн бол тайлант хугацааны орлогын төлөвлөгөөний биелэлт 98.7 хувьтай байна.

Төсвийн нийт зарлагын хувьд: Нэгдсэн төсвийн нийт зарлага 2023 оны эхний улирлын байдлаар 4,138.2 тэрбум төгрөгт хүрч, 77.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 315.5 тэрбум төгрөгөөр буюу 8.3 хувиар нэмэгдсэн байна.

Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарлаа. 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 5,703.6 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 57.0 хувь буюу 2,070.9 сая ам.доллаароор өсөж, гадаад худалдааны тэнцэл 1,824.4 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Мөнгөний нийлүүлэлт өслөө. Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) 2023 оны эхний улирлын байдлаар 30,938.8 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 4,455.8 тэрбум төгрөг буюу 16.8 хувиар өссөн байна. Үүнд төгрөгийн хадгаламж 4.5 хувиар буурсан ч, гадаад валютын харилцах 2,324.2 тэрбум төгрөг буюу 83.7 хувиар, гадаад валютын хадгаламж 1,674.4 тэрбум төгрөг буюу 39.1 хувиар, M1 мөнгө 1,068.2 тэрбум төгрөг буюу 18.7 хувиар өссөн нь тус тус нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс буурсан. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 3 дугаар сард улсын хэмжээнд өнгөрсөн оны мөн үеэс 3.5 нэгж хувиар буурсан байна.

Төлбөрийн тэнцэл ашигтай гарлаа. 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 61.3 сая ам.долларын, хөрөнгийн тэнцэл 8.1 сая ам.долларын, санхүүгийн тэнцэл 81.7 сая ам.долларын ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 13.4 сая ам.долларын ашигтай гарахад нөлөөлжээ. Төлбөрийн тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 395.6 сая ам.доллараар сайжирсан байна.

Гадаад валютын ханш өсжээ. 2023 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 3,524.9 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 623.2 төгрөгөөр /21.5 хувь/ суларсан байна.

Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 511.4 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 54.1 төгрөгөөр /11.8 хувь/ суларчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны эхний улирлын байдлаар 1,383.6 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 414.3 тэрбум төгрөг буюу 42.7 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.0 хувийг эзэлж байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ өсжээ. 2023 оны эхний улирлын байдлаар 2.2 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 101.1 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.6 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеийн түвшинд хэвээр байна.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

НЭГ. БОДИТ СЕКТОРЫН ҮЗҮҮЛЭЛТ

1.1. Дотоодын нийт бүтээгдэхүүн:


Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ:

2023 оны эхний улирлын байдлаар бодит ДНБ-ий хэмжээ 2015 оны зэрэгцүүлэх үнээр 5.6 их наяд төгрөг болж, эдийн засаг 7.9 хувьд хүрч тэлсэн байна.

2021 оны эхний улиралд ДНБ-ий бодит өсөлт 14.8 хувьд хүрч уналтын дараах сэргэлт (V хэлбэрийн сэргэлт) гарсан хэдий боловч энэхүү өсөлт 2022 оны эхний улирал хүртэлх хугацаанд саарч, 2022 оны 2 дугаар улирлаас өсөж, 2023 оны эхний улирлын байдлаар 7.9 хувийн өсөлттэй гарлаа. График 1-д 2016-аас 2023 оны эхний улирлын байдлаарх ДНБ-ий хэмжээ болон мөн хугацааны улирал бүрийн эдийн засгийн бодит өсөлтийн хоорондох хамаарлыг харуулав.

Манай улсын гадаад эрэлтийг голлон тодорхойлогч БНХАУ-д “Тэг-Ковид” бодлогын хязгаарлалт суларсантай холбоотойгоор экспортын гол нэрийн барааны үнэ болон уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв сайжирч байна.

График 1. Нэрлэсэн ДНБ-ий хэмжээ ба ДНБ-ий бодит өсөлт, улирлаар



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны эхний улирлын байдлаар оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 13.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 42.1 хувь буюу 4.0 их наяд төгрөгөөр өссөн бол 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ-ий хэмжээ 5.6 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 7.9 хувь буюу 0.4 их наяд төгрөгөөр өссөн байна.

Энэхүү өсөлтөд уул уурхай, тээвэр ба агуулах, худалдаа, үйлчилгээний салбарын өсөлт голлон нөлөөлжээ. Тухайлбал, уул уурхайн салбарын өсөлт 5.3 нэгж хувь, тээврийн салбарын өсөлт 2.1 нэгж хувь, худалдаа 1.0 нэгж хувийг бүрдүүлжээ.


Уул уурхайгаас бусад салбаруудын эдийн засгийн өсөлтийг дурдвал, худалдаа, үйлчилгээний салбарууд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 нэгж хувиар, аж үйлдвэр, барилгын салбар 0.7 нэгж хувиар өссөн байна. Харин өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөө аж ахуйн салбар 0.7 нэгж хувиар буурчээ.

Хүснэгт 1. Эдийн засгийн өсөлтийн бүтэц, салбараар /нэгж хувиар/

Үзүүлэлт	2020				2021				2022				2023
	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	I
	Эдийн засгийн өсөлтийн өөрчлөлт, салбараар /хувь/												
ДНБ-ий бодит өсөлт	-10.1	-9.0	-6.7	-4.6	14.8	6.3	3.7	1.6	-3.9	1.9	3.7	4.8	7.9
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	0.5	1.7	1.6	0.8	-0.2	-0.8	-0.8	-0.8	0.5	1.8	1.6	1.7	-0.2
Уул уурхай, олборлолт	-6.0	-4.6	-3.3	-1.4	5.2	2.6	1.3	0.1	-6.1	-3.7	-2.3	-1.6	5.3
Боловсруулах үйлдвэрлэл	0.1	-0.4	-0.4	0.3	1.6	0.7	0.4	-0.1	-0.7	-0.1	0.1	0.5	-0.5
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.2	0.1	0.0	0.0	0.3	0.3	0.2	0.2	0.2	0.2	0.1	0.1	0.2
Барилга	0.2	0.0	-0.1	-0.1	0.0	-0.9	-0.9	-0.9	-0.4	-0.1	0.1	0.2	0.0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	-1.5	-1.6	-1.6	-1.4	0.6	0.5	0.5	0.6	0.7	1.2	1.1	0.9	1.0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	-1.6	-1.3	-1.1	-1.0	0.7	0.3	0.0	-0.3	-1.4	-0.7	-0.1	0.1	2.1
Мэдээлэл, холбоо	0.1	0.1	0.1	0.1	0.4	0.5	0.4	0.5	0.4	0.4	0.2	0.2	0.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	-1.1	-1.3	-0.8	-0.7	0.3	0.1	0.6	1.1	1.3	1.4	1.1	1.4	0.5
Бүтээгдэхүүний цэвэр татвар	-1.0	-1.6	-1.1	-1.1	5.8	3.0	1.9	1.3	1.6	1.7	1.7	1.4	-0.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 2. Нэрлэсэн ДНБ, өөрчлөлт /оны үнээр, их наяд төгрөгөөр/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 3. Бодит ДНБ, өөрчлөлт /2015 оны зэрэгцүүлэх үнээр, их наяд төгрөгөөр/



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2021 оны эхний улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 14.8 хувьтай гарч байсан бол 2022 оны эхний улирлын гүйцэтгэлээр -3.9 хувьд хүрч буурсан ба энэ оны эхний улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 11.8 нэгж хувиар өссөн байна.

Эдийн засаг 11.8 нэгж хувиар өсөхөд өмнөх оны мөн үеийн өсөлтөөс хөдөө аж ахуйн салбар 0.7 нэгж хувиар буурсан хэдий ч уул уурхай 11.4 нэгж хувь, аж үйлдвэр, барилга 0.7 нэгж хувь, тээвэр ба агуулахын үйлчилгээ 3.5 нэгж хувиар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. ДНБ-ий өсөлт дэх салбаруудын оролцоо, /нэгж хувиар/

Салбараар	Эхний улирлын байдлаар			Өөрчлөлт
	2021	2022	2023	
ДНБ-ий бодит өсөлт	14.8	-3.9	7.9	11.8
Хөдөө аж ахуй	-0.2	0.5	-0.2	-0.7
Уул уурхай, олборлолт	5.2	-6.1	5.3	11.4
Аж үйлдвэр, барилга	1.6	-1.1	-0.5	0.7
Боловсруулах үйлдвэрлэл	1.6	-0.7	-0.5	0.3
Барилга	0.0	-0.4	0.0	0.4
Худалдаа, үйлчилгээ	2.4	1.3	4.0	2.7
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.3	0.2	0.2	-0.1
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	0.6	0.7	1.0	0.3
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0.7	-1.4	2.1	3.5
Мэдээлэл, холбоо	0.4	0.4	0.2	-0.3
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	0.3	1.3	0.5	-0.8
Бүтээгдэхүүний цэвэр татвар	5.8	1.6	-0.7	-2.2

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ:

Оны үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 2023 оны эхний улирлын байдлаар 13.7 их наяд төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 44.6 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон ДНБ-ий хэмжээ 6.1 их наяд төгрөг болж өнгөрсөн оноос 7.8 хувиар тус тус өссөн байна.

Хүснэгт 3. Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр, өссөн дүнгээр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2019-1	2020-1	2021-1	2022-1	2023-1	Өөрчлөлт (хувиар)
ДНБ	7,665.2	7,133.6	9,084.9	9,444.7	13,661.5	44.6
Эцсийн хэрэглээ	6,166.3	6,975.7	6,316.1	7,613.7	8,646.4	13.6
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	5,075.4	5,707.6	5,194.0	6,378.6	7,094.9	11.2
Төрийн байгууллагын хэрэглээ	1,090.9	1,268.1	1,122.1	1,235.1	1,551.5	25.6
Хөрөнгийн нийт хуримтлал	1,980.9	2,003.6	2,491.0	3,307.9	3,216.8	-2.8
Үндсэн хөрөнгийн хуримтлал	1,949.8	1,768.6	2,028.6	2,146.8	2,814.9	31.1
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	31.1	234.9	462.4	1,161.1	401.8	-65.4
Цэвэр экспорт	-482.0	-1,845.7	277.9	-1,476.9	1,798.3	-221.8
Бараа, үйлчилгээний экспорт	4,974.3	2,836.2	5,930.0	5,159.8	12,882.5	149.7
Бараа, үйлчилгээний импорт	5,456.3	4,681.9	5,652.1	6,636.6	11,084.2	67.0


Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 4. Эцсийн ашиглалтын аргаар ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, өссөн дүнгээр

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	2019-I	2020-I	2021-I	2022-I	2023-I	Өөрчлөлт (хувиар)
ДНБ	5,481.7	5,081.6	5,849.1	5,626.2	6,063.5	7.8
Эцсийн хэрэглээ	5,298.7	5,699.0	5,047.5	5,432.0	5,551.6	2.2
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	4,348.7	4,637.5	4,098.7	4,461.2	4,437.3	-0.5
Төрийн байгууллагын хэрэглээ	950.0	1,061.5	948.8	970.8	1,114.3	14.8
Хөрөнгийн нийт хуримтлал	1,643.4	1,473.8	1,904.5	2,196.9	1,614.2	-26.5
Үндсэн хөрөнгийн хуримтлал	1,616.3	1,367.9	1,534.4	1,422.9	1,387.4	-2.5
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	27.1	105.9	370.1	774.0	226.8	-70.7
Цэвэр экспорт	-1,460.4	-2,091.3	-1,102.8	-2,002.7	-1,102.3	-45.0
Бараа, үйлчилгээний экспорт	2,993.4	1,716.9	3,123.0	2,321.3	5,627.9	142.5
Бараа, үйлчилгээний импорт	4,453.8	3,808.2	4,225.9	4,323.9	6,730.2	55.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 4. ДНБ, эцсийн ашиглалтын аргаар /их наяд төгрөгөөр/

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны эхний улирлын байдлаар эдийн засаг 7.8 хувиар өсөхөд бараа үйлчилгээний экспорт, импортын өсөлт голлон нөлөөлжээ.

Хүснэгт 5. ДНБ-ий бодит өсөлт, салбараар /хувиар/

Үзүүлэлт	2021				2022				2023
	I	II	III	IV	I	II	III	IV	I
ДНБ	15.1	6.2	3.4	1.6	-3.8	1.9	3.7	4.7	7.8
Эцсийн хэрэглээ	-11.4	-8.9	-8.3	-2.7	7.6	6.4	6.5	6.9	2.2
Өрхийн хэрэглээ, Өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллагын хэрэглээ	-11.6	-9.2	-8.4	-5.9	8.8	6.9	7.2	7.4	-0.5
Төрийн байгууллагын хэрэглээ	-10.6	-7.7	-8.0	9.2	2.3	4.3	3.6	5.4	14.8
Хөрөнгийн нийт хуримтлал	29.2	44.7	78.2	80.7	15.4	43.3	20.1	15.5	-26.5
Үндсэн хөрөнгийн хуримтлал	12.2	12.6	2.8	17.7	-7.3	2.2	2.0	0.3	-2.5
Материаллаг эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт, үнэт зүйлсийн хуримтлал	249.4	412.9	-1,210.6	-1,403.0	109.1	146.6	48.8	47.9	-70.7
Цэвэр экспорт	-47.3	-9.4	55.0	142.2	81.6	93.5	40.1	-	-
Бараа, үйлчилгээний экспорт	81.9	14.0	-9.0	-14.6	-25.7	-16.0	13.3	31.3	142.5
Бараа, үйлчилгээний импорт	11.0	5.4	8.5	13.6	2.3	18.3	23.8	30.5	55.7

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

1.2. Нэг хүнд ногдох ДНБ

Бүтээмжийг нэг хүнд ногдох бодит ДНБ-ээр илэрхийлдэг. Монгол Улсын хувьд, Үндэсний статистикийн хорооноос 2015 оноос хойш улирал бүр уул уурхай, аж үйлдвэр, барилга, хөдөө аж ахуй болон үйлчилгээний салбарын бүтээмжийн талаарх статистик тоон мэдээллийг нийтэлдэг болсон. Бүтээмжийг 2015 оны зэрэгцүүлэх үнээр нэг ажиллагчид ногдох ДНБ-ээр илэрхийлэн тооцоолж байна.

Бүтээмж 2023 оны эхний улирлын байдлаар 4.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.0 хувиар буюу 434.3 мянган төгрөгөөр өссөн байна. Салбараар нь авч үзвэл, уул уурхайн салбарын бүтээмж 3.1 сая төгрөг (31.3 хувь), аж үйлдвэр, барилгын салбар 406.8 мянган төгрөг (12.7 хувь), үйлчилгээний салбар 325.6 мянган төгрөг (7.4 хувь)-өөр тус тус нэмэгдсэн боловч хөдөө аж ахуйн салбарын бүтээмж 43.9 мянган төгрөг (5.4 хувь)-өөр буурчээ.

Хүснэгт 6. Нэг хүнд ногдох ДНБ буюу бүтээмжийн харьцуулалт

/мянган төгрөгөөр/

Бүрэлдэхүүн	Эхний улирлын байдлаар				Өөрчлөлт 2023/2022	
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Хөдөлмөрийн бүтээмжийн түвшин	3,718.3	4,818.2	4,322.8	4,757.1	434.3	10.0
Хөдөө аж ахуй	886.6	719.6	809.4	765.5	(43.9)	-5.4
Уул уурхай, олборлолт	11,803.8	18,136.9	9,930.2	13,035.1	3,104.9	31.3
Аж үйлдвэр, барилга	3,309.4	4,108.6	3,192.9	3,599.7	406.8	12.7
Үйлчилгээ	3,394.5	4,538.2	4,370.9	4,696.5	325.6	7.4

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2023 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 4,794.8 тэрбум төгрөг, нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүн 4,138.2 тэрбум төгрөгт хүрч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 656.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 2023 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр 4,794.8 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1,226.8 тэрбум төгрөг буюу 34.4 хувиар, төсвийн нийт зарлага 315.5 тэрбум төгрөг буюу 8.3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Хүснэгт 7. Монгол Улсын нэгдсэн төсөв

/тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Биелэлт, хувиар	Өөрчлөлт(+/-)	
					2023.03/2022.03	
	1	2	3	(3:1)	(3-2)	(3-2)/2
	2023.03	2022.03	2023.03	Төл/гүйц	Дүн	Хувь
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	4,855.8	3,568.0	4,794.8	98.7	1,226.8	34.4
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	5,319.3	3,822.7	4,138.2	77.8	315.5	8.3
Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-463.5	-254.7	656.6	-141.7	911.3	-357.9
ДНБ, оны үнээр		9,578.9	13,614.2		4,035.4	
Төсвийн тэнцлийн ДНБ-д эзлэх хувь		-2.7	4.8		7.5	

Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

2023 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 656.6 тэрбум төгрөгийн ашигтай гарч, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын бүрдүүлэлт 98.7 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ 4.8 хувь болж, өмнөх оны мөн үеэс 7.5 нэгж хувиар өссөн нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн хэмжээ 911.3 тэрбум төгрөгөөр өсөж, 656.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсантай холбоотой байна.

2.1. Нэгдсэн төсвийн орлого:

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 4,794.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 34.4 хувиар буюу 1,226.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 60.9 тэрбум төгрөг буюу 1.3 хувиар дутуу биелсэн байна.

Тэнцвэржүүлсэн нийт орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал тус бүрээр авч үзвэл нийгмийн даатгалын сангийн төсөв 5.8 хувь буюу 50.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол улсын төсөв 8.3 хувь буюу 297.8 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 6.8 хувь буюу 56.2 тэрбум төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 3.5 хувь буюу 13.7 тэрбум төгрөгөөр тус тус дутуу төвлөрсөн байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 50.6 хувь буюу 1,111.2 тэрбум төгрөг, орон нутгийн төсөв 33.9 хувь буюу 195.4 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сан 34.8 хувь буюу 239.5 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 32.7 хувь буюу 92.9 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 8. Нэгдсэн төсвийн орлогын 2023 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

/тэрбум төгрөгөөр/

Ангилал	Улсын төсөв		Орон нутгийн төсөв		НДС		ЭМДС	
	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц	Төл	Гүйц
Нийт орлого ба тусламжийн дүн	3,630.0	3,586.8	828.1	771.9	877.6	928.1	390.3	376.6
Ирээдүй өв сан	0.0	0.2	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Тогтворжуулалтын сан	23.7	278.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	3,606.4	3,308.6	828.1	771.9	877.6	928.1	390.3	376.6
Татварын орлого	3,062.7	3,088.5	632.9	613.5	686.3	745.7	390.3	376.6
Татварын бус орлого	543.6	220.1	195.2	158.5	191.3	182.4	0.0	0.0


Эх сурвалж: Сангийн яам, Үндэсний статистикийн хороо

Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 94.6 хувийг татварын орлого, 5.4 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Нэгдсэн төсвийн татварын орлого 4,535.2 тэрбум төгрөг болж, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 1.3 хувиар буюу 59.4 тэрбум төгрөгөөр давж биелсэн, өнгөрсөн оны мөн үеэс 34.8 хувь буюу 1,171.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2023 онд Тогтворжуулалтын санд 132.7 тэрбум, Ирээдүйн өв санд 540.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөснөөс энэ оны 1 дүгээр улирлын байдлаар Тогтворжуулалтын санд 278.0 тэрбум төгрөг, Ирээдүй өв санд 160 сая төгрөг төвлөрүүлсэн байна. Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлого 109.5 хувь буюу 145.3 тэрбум төгрөгөөр давж биелсэн, харин Ирээдүйн өв санд төвлөрүүлэх орлого 0.03 хувийн биелэлттэй байна.

Татварын орлого: Татварын орлогын 31.5 хувийг орлогын албан татвар, 18.4 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.4 хувийг хөрөнгийн албан татвар, 21.7 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 3.7 хувийг онцгой албан татвар, 0.1 хувийг тусгай зориулалтын орлого, 6.9 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 16.3 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлсэн байна.

График 5. Татварын бус орлогын бүтэц /хувиар/

Эх сурвалж: Сангийн яам

2023 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр татварын орлого төлөвлөснөөс 1.3 хувь буюу 59.4 тэрбум төгрөгөөр давж биелэхэд орлогын албан татвар 16.1 хувь (198.6 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 6.8 хувь (53.1 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 0.7 хувь (7.3 тэрбум төгрөг)-аар тус тус давж биелсэн нь нөлөөлжээ.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2023 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр татварын орлого 34.8 хувь буюу 1,171.3 тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 73.1 хувь (604.3 тэрбум төгрөг), нийгмийн даатгалын орлого 31.3 хувь (198.7 тэрбум төгрөг), хөрөнгийн албан татвар 22.0 хувь (11.3 тэрбум төгрөг), нэмэгдсэн өртгийн албан татвар 19.2 хувь (158.4 тэрбум төгрөг), гадаад үйл ажиллагааны орлого 27.9 хувь (68.4 тэрбум төгрөг), бусад татвар, төлбөр, хураамж 42.2 хувь (220.1 тэрбум төгрөг)-аар тус тус өссөн нь нөлөөлжээ.

Татварын бус орлого 259.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 55.5 тэрбум төгрөгөөр өссөн бол төлөвлөснөөс 120.3 тэрбум төгрөг буюу 31.7 хувиар дутуу биелжээ.

Татварын бус орлого: Татварын бус орлогын 87.9 хувийг нийтлэг татварын бус орлого, 11.8 хувийг тусламжийн орлого, 0.3 хувийг хөрөнгийн орлого эзэлж байна.

Нийтлэг татварын бус орлогыг бүрдүүлэгч эх үүсвэрүүдийг бүтцийн хувьд авч үзвэл 43.7 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 23.3 хувийг газрын тосны орлого, 13.8 хувийг торгуулийн орлого, 12.1 хувийг бусад орлого, 6.9 хувийг хүүгийн орлого, 0.3 хувийг түрээсийн орлого бүрдүүлж байна.

График 6. Татварын бус орлогын бүтэц /хувиар/



Эх сурвалж: Сангийн яам

Төлөвлөгөөтэй харьцуулахад төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 0.6 тэрбум төгрөгөөр илүү төвлөрч, гадаад хандив тусламжийн орлого 41.1 тэрбум төгрөгөөр дутуу биелжээ.

Нийтлэг татварын бус орлогоос төсөвт байгууллагын өөрийн орлого 24.4 тэрбум төгрөг, торгуулийн орлого 20.5 тэрбум төгрөгөөр давж биелсэн бол газрын тосны орлого 61.7 тэрбум төгрөг, хүүгийн орлого 33.6 тэрбум төгрөг, бусад орлого 4.6 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрсөн байна. Харин навигацийн орлого болон хувьцааны ногдол ашгийн орлого тайлант хугацаанд төвлөрөөгүй байна.

2.2. Нэгдсэн төсвийн нийт зарлага

2023 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 5,319.3 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 77.8 хувийг зарлагдаж 1,181.1 тэрбум төгрөгийн дутуу зарцуулалттай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 315.5 тэрбум төгрөг буюу 8.3 хувиар өсөж, 4,138.2 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.

Хүснэгт 9. Нэгдсэн төсвийн зарлага /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлт	Гүйцэтгэл /2022.03/	2023 оны 1 дүгээр улирал			
		Төл.	Гүйц.	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,822.7	5,319.3	4,138.2	77.8	-1,181.1
Нийт зарлага	3,818.8	5,335.4	4,157.7	77.9	-1,177.7
Урсгал зардал	3,350.7	4,468.8	3,669.7	82.1	-799.2
Бараа, ажил үйлчилгээний зардал	762.5	1,361.0	938.5	69.0	-422.5
Хүү	169.6	429.5	332.6	77.4	-96.9
Татаас	134.0	188.8	122.0	64.6	-66.8
Урсгал шилжүүлэг	2,284.7	2,489.6	2,276.6	91.4	-213.0
Хөрөнгийн зардал	468.1	866.6	488.0	56.3	-378.6
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	3.9	-16.2	-19.5	120.8	-3.4

Эх сурвалж: Сангийн яам

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 318.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нэгдсэн төсвийн зарлагын 88.7 хувь буюу 3,669.7 тэрбум төгрөг нь урсгал зардал, үүний дотор 62.0 хувийг урсгал шилжүүлэг, 25.6 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 9.1 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 3.3 хувийг татаас тус тус эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татаас 11.9 тэрбум, урсгал шилжүүлэг 8.1 тэрбум төгрөгөөр буурсан ч, бараа, ажил үйлчилгээний зардал 176.0 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 163.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Түүнчлэн хөрөнгө оруулалтын зардал 20.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

ГУРАВ. ГАДААД ХУДАЛДАА**3.1. Гадаад худалдааны эргэлт:**

Монгол Улс 2023 оны эхний улиралд 125 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 5,703.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2,070.9 сая ам.доллар буюу 57.0 хувиар өссөн байна. Үүнд экспорт 1,822.0 сая ам.доллараар, импорт 248.9 сая ам.доллараар өссөн байна.

2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр экспорт импортын дүнгээс 1,824.4 сая ам.доллараар давж, экспортын худалдаа 3,764.0 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 93.8 хувиар, мөн импорт 1,939.6 сая ам.долларт хүрч 14.7 хувиар нэмэгдсэн нь гадаад худалдааны ашгийг 1,573.0 сая ам.доллараар буюу 7.3 дахин нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 10. Гадаад худалдааны үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний улирлын байдлаар					Өөрчлөлт	
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Нийт эргэлт	3,057.4	2,197.4	3,524.1	3,632.7	5,703.6	2,070.9	57.0
Экспорт	1,771.7	1,035.8	2,000.4	1,942.0	3,764.0	1,822.0	93.8
Импорт	1,285.7	1,161.6	1,523.7	1,690.7	1,939.6	248.9	14.7
Тэнцэл	485.9	-125.8	476.7	251.4	1,824.4	1,573.0	7.3 дахин

/сая ам.доллар/

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: Тайлант хугацаанд худалдааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 1,573.0 сая ам.доллараар өсөж 1,824.4 сая ам.долларын ашигтай гарлаа. Гадаад худалдааны ашиг өмнөх оны мөн үеэс 1,593.0 сая ам.доллараар буюу 7.3 дахин өссөн байна.

Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл 2023 оны эхний улирлын байдлаар 1,870.4 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 1,612.6 сая ам.доллараар өссөн байна.

Валютын төлбөртэй барааны тэнцэл өсөхөд валютын төлбөртэй экспорт 1,829.3 сая ам.доллараар, валютын төлбөртэй импорт 216.7 сая ам.доллараар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 11. Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл


/сая.ам.доллараар/

Үзүүлэлт	Эхний улирал		Өөрчлөлт	
	2022	2023	Дүн	Хувь
	2022 он	2023 он	Дүн	Хувь
А.Экспорт	1,942.0	3,764.0	1,822.0	93.8
Валютын төлбөртэй бараа	1,910.7	3,740.0	1,829.3	95.7
Валютын төлбөртэй экспортын нийт экспортод эзлэх хувь	98.4	99.4	1.0	1.0
Б.Импорт	1,690.7	1,939.6	248.9	14.7
Валютын төлбөртэй бараа	1,652.9	1,869.6	216.7	13.1
Валютын төлбөртэй импортын нийт импортод эзлэх хувь	97.8	96.4	-1.4	-1.4
Валютын төлбөртэй барааны худалдааны тэнцэл	257.8	1,870.4	1,612.6	625.6

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Экспорт, импортын жилийн өсөлт: Экспорт болон импортын жилийн өсөлтийн хурдыг 3 сарын гулсах дундаж (2011.01-2023.03)-аар тооцон үзэв. 2013 онд Оюутолгойн уурхайн төсөл эхэлж, олборлолт, борлуулалт хийснээр экспортын тоо хэмжээ 2014-2015 онуудад өссөн. 2020 оны эхний 5 сарыг эс тооцвол 2014 оны 10 сараас хойш гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан байна.

График 7. Гадаад худалдааны үзүүлэлт



Хөрш орнуудтай хийсэн худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт, экспорт болон импортын худалдаанд хөрш ОХУ болон БНХАУ томоохон хувийг эзэлдэг. Тухайлбал, 2023 оны эхний улирлын байдлаар хөрш орнууд гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 83.4 хувь, экспортын 93.0 хувь, импортын 64.9 хувийг тус тус эзэлж байна. 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 73.9 хувь буюу 4,217.5 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, мөн 9.5 хувь буюу 539.4 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийсэн байна. Харин бусад улс оронтой хийсэн худалдаа нийт бараа эргэлтийн 16.6 хувийг эзэлж байна. БНХАУ нийт экспортын 92.4 хувь /3.5 тэрбум ам.доллар/, нийт импортын 38.2 хувь /0.7 тэрбум ам.доллар/-ийг эзэлж байгаа бол ОХУ-ын хувьд нийт экспортын 0.6 хувь, нийт импортын 26.7 хувь /0.5 тэрбум ам.доллар/-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 12. Хөрш орнуудын гадаад худалдааны үзүүлэлт

/сая ам.доллар/

Улс орон	Төрөл	Эзлэх хувь /2023.03 сар/	Эхний 3 сарын гүйцэтгэл				Өөрчлөлт (+/-)	
			2020	2021	2022	2023	2023.03/2022.03	
							Дүн	Хувь
БНХАУ	Нийт эргэлт	73.9	1,236.9	2,440.8	2,048.2	4,217.5	2,169.3	105.9
	Экспорт	92.4	904.6	1,849.7	1,528.5	3,476.3	1,947.8	127.4
	Импорт	38.2	332.3	591.2	519.7	741.1	221.5	42.6
	Тэнцэл		572.3	1,258.5	1,008.9	2,735.2	1,726.3	171.1
ОХУ	Нийт эргэлт	9.5	400.6	437.4	583.3	539.4	-43.9	-7.5
	Экспорт	0.6	11.0	27.8	42.8	21.9	-20.9	-48.8
	Импорт	26.7	389.6	409.6	540.5	517.5	-23.0	-4.2
	Тэнцэл	-	-378.6	-381.8	-497.6	-495.6	2.1	-0.4
Бусад	Нийт эргэлт	16.6	559.8	645.9	1,001.3	946.7	-54.5	-5.4
	Экспорт	7.1	120.2	122.9	370.7	265.7	-105.0	-28.3
	Импорт	35.1	439.6	522.9	630.6	681.0	50.4	8.0
	Тэнцэл	-	-319.4	-400.0	-259.8	-415.2	-155.4	59.8

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2023 оны эхний улирлын байдлаар БНХАУ-тай хийсэн худалдаа 2,735.2 сая.ам.долларын ашигтай, ОХУ-тай хийсэн худалдаа -495.6 сая.ам. долларын, бусад орнуудтай хийсэн худалдаа -415.2 сая. ам.долларын алдагдалтай гарсан байна.

3.2. Экспорт:

Экспортын худалдаа 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр 3,764.0 сая ам.доллар болж, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үе буюу 2020 оны мөн үетэй харьцуулахад 2,728.2 сая ам.доллар буюу 3.6 дахин өссөн бол 2022 оны мөн үеэс 1,822.0 сая ам.доллар буюу 93.8 хувиар өссөн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 3,331.9 сая ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 1,800.6 сая ам.доллар буюу 117.6 хувиар өссөн, харин эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 432.1 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 21.4 сая ам.доллар буюу 5.2 хувиар өссөн байна. Эрдсийн бүтээгдэхүүний нийт экспортод эзлэх хувийн жин 2023 оны эхний улирлын байдлаар 88.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 9.6 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь эрдсийн бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой. Тухайлбал, өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын хэмжээ 11.6 сая/тн-оор буюу 5.6 дахин өссөн байна.

Хүснэгт 13. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт


/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний улирлын байдлаар					Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	1,478.9	886.0	1,776.2	1,531.3	3,331.9	1,800.6	117.6	88.5
Эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт	292.7	149.8	224.2	410.7	432.1	21.4	5.2	11.5
Нийт экспорт	1,771.7	1,035.8	2,000.4	1,942.0	3,764.0	1,822.0	93.8	100.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны эхний улирлын байдлаар нийт экспортын орлогын 60.3 хувийг нүүрс, 16.8 хувийг зэсийн баяжмал, 4.1 хувийг боловсруулаагүй болон хагас боловсруулсан алтны экспортын орлого эзэлж байна.


График 8. Гол нэр төрлийн барааны экспорт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Доорх графикуудаар зэсийн баяжмал, нүүрс, төмрийн хүдрийн экспортын орлого, тоо хэмжээ болон үнийн өөрчлөлтийг бүтээгдэхүүн бүрээр харууллаа.

График 9. Зэсийн баяжмалын экспортын өөрчлөлт




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 10. Нүүрсний экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

График 11. Төмрийн хүдрийн экспортын өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 14. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын тоо хэмжээ, төрлөөр

Гол нэр төрлийн бараа	Хэмжих нэгж	1 дүгээр улирал				Өмнөх оны мөн үеэс	
		2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	тн	1.6	0.4	4.8	2.6	(2.3)	-46.8
Зэсийн баяжмал	мян.т	306.6	316.3	334.8	362.9	28.0	8.4
Төмрийн хүдэр, баяжмал, пирит	мян.т	2,061.8	1,912.6	616.2	1,304.2	688.0	111.7
Цайрын баяжмал	мян.т	36.9	31.0	21.9	57.9	36.1	165.1
Нүүрс	мян.т	3,138.3	6,773.8	2,523.2	14,142.8	11,619.6	5.6 дахин
Боловсруулаагүй нефть	мян.барр	322.3	1,422.1	-	1,159.7	1,159.7	-

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 15. Гол нэр төрлийн бүтээгдэхүүний экспортын орлого

/сая ам.доллар/

Гол нэр төрлийн бараа	1 дүгээр улирал				Өмнөх оны мөн үеэс	
	2020	2021	2022	2023	Дүн	Хувь
Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт	80.4	25.7	288.0	156.0	-132.0	-45.8%
Зэсийн баяжмал	351.2	621.1	710.9	631.6	-79.3	-11.2%
Төмрийн хүдэр, баяжмал, пирит	141.1	238.5	57.5	109.5	52.0	90.5%
Цайрын баяжмал	48.3	46.4	41.2	98.1	56.9	138.1%
Нүүрс	252.9	692.3	675.6	2,269.4	1,593.9	3.4 дахин
Боловсруулаагүй нефть	17.7	78.4	0.0	88.5	88.5	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 1,800.6 сая ам.доллар буюу 117.6 хувиар өсөхөд голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

Нүүрс: 2023 оны эхний улирлын байдлаар 14.1 сая тонн нүүрс экспортолж, 2,269.4 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өнгөрсөн оны мөн үеэс экспортын биет хэмжээ 5.6 дахин өссөн нь нүүрсний экспортын орлого 1,593.9 сая ам.доллараар буюу 3.4 дахин өсөхөд нөлөөлсөн байна.

Боловсруулаагүй нефть: 2023 оны эхний эхний 3 сард боловсруулаагүй нефтийн экспорт 1,159.7 мянган баррель буюу 88.5 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 100 хувийн өсөлттэй байна.

Цайрын баяжмал: 2023 оны эхний улирлын байдлаар цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 57.9 мянган тоннд хүрч, 98.1 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын биет хэмжээ 165.1 хувь буюу 36.1 мянган тонноор өссөн нь цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 138.1 хувь буюу 56.9 сая ам.доллараар өсөхөд нөлөөлжээ.

Төмрийн хүдэр: 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр 1.3 сая тонн төмрийн хүдэр экспортолж, 109.5 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Өнгөрсөн оны мөн үеэс төмрийн хүдрийн экспортын орлого 90.5 хувь буюу 52.0 сая ам.доллараар өсөхөд төмрийн хүдрийн биет хэмжээ 111.7 хувь буюу 688.0 мян.тн-оор өссөн нь нөлөөлжээ.

Харин дараах эрдэс бүтээгдэхүүний экспортын орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан байна. Үүнд:

Алт: 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр 2.6 тонн алт экспортолж, экспортын орлого 156.0 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 45.8 хувиар буурсан байна. Өмнөх оны мөн үеэс алтны экспортын биет хэмжээ 46.8 хувиар буурсан нь алтны экспортын орлогыг бууруулжээ.

Зэсийн баяжмал: 2023 оны эхний улирлын байдлаар 362.9 мянган тонн зэсийн баяжмал экспортолж, экспортын орлого 631.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 11.2 хувиар буурсан байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмалын экспорт 28.0 мянган тонноор өсөж, экспортын орлого 79.3 сая ам.доллараар буурчээ.

Нийт экспортын орлогын 60.2 хувийг нүүрс, 16.8 хувийг зэсийн баяжмал, 4.1 хувийг алт, 2.9 хувийг төмрийн баяжмал, 2.6 хувийг цайрын баяжмал, 2.4 хувийг боловсруулаагүй нефть эзэлсэн байна.

3.3. Импорт:

2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр нийт импортын худалдаа 1,939.6 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 14.7 хувь буюу 248.9 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт импортын 25 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 75 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний импорт 484.0 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 97.5 сая ам.доллар буюу 25.2 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 1,455.6 сая ам.доллар болж, өнгөрсөн оны мөн үеэс 151.4 сая ам.доллар буюу 11.6 хувиар өсжээ.

Хүснэгт 16. Эрдсийн бүтээгдэхүүний импорт

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний улирал					Өөрчлөлт		Нийт импортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	2023	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	315.4	284.0	275.7	386.5	484.0	97.5	25.2	25.0
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	970.3	877.6	1,247.0	1,304.2	1,455.6	151.4	11.6	75.0
Нийт импорт	1,285.7	1,161.6	1,522.7	1,690.7	1,939.6	248.9	14.7	100.0

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2023 оны эхний улирлын байдлаар импортын 30.0 хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 39.0 хувийг хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, 10.0 хувийг аж үйлдвэрлэлийн орц, 22.0 хувийг нефтийн бүтээгдэхүүн эзэлсэн байна.

Хүснэгт 17. Гол нэр төрлийн импортын барааны гүйцэтгэл

/сая ам.доллар/


Бүтээгдэхүүн	Эхний улирал						Өөрчлөлт (Сая ам.дол)
	2021		2022		2023		2023/2022
	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	Сая ам.дол	Эзлэх хувь	
Хэрэглээ	446.0	29.0	609.0	36.0	573.0	30.0	-36.0
- Түргэн эдэлгээтэй	252.0	17.0	346.0	20.0	296.0	15.0	-51.0
- Удаан эдэлгээтэй	194.0	13.0	263.0	16.0	277.0	15.0	14.0
Хөрөнгө оруулалт	634.0	42.0	542.0	32.0	752.0	39.0	210.0
- Машин, механик тоног төхөрөөмж, эд анги	469.0	31.0	296.0	17.0	521.0	27.0	225.0
- Барилгын материал	107.0	7.0	184.0	11.0	164.0	8.0	-20.0
- Хөрөнгө оруулалтын бусад бараа	58.0	4.0	62.0	4.0	67.0	3.0	5.0
Аж үйлдвэрлэлийн орц	210.0	14.0	204.0	12.0	189.0	10.0	-15.0
- Хүнсний орц	63.0	4.0	5.0	0.0	6.0	0.0	0.0
- Химийн бүтээгдэхүүн	26.0	2.0	41.0	2.0	33.0	2.0	-8.0
- Цахилгаан эрчим хүч	41.0	3.0	46.0	3.0	49.0	3.0	4.0
- Бусад АҮ-ийн орц	73.0	5.0	103.0	6.0	93.0	5.0	-10.0
Нефтийн бүтээгдэхүүн	230.0	15.0	330.0	20.0	423.0	22.0	93.0
- Дизель	136.0	9.0	151.0	9.0	261.0	13.0	110.0
- АИ-92, 95	50.0	3.0	138.0	8.0	111.0	6.0	-27.0
- А80 ба бусад	44.0	3.0	33.0	2.0	52.0	2.0	11.0
Нийт дүн	1,524.0		1,691.0		1,940.0		249.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

2022 оны мөн үетэй харьцуулахад 2023 оны эхний улирлын байдлаар импортын худалдаа 249.0 сая ам.доллаар нэмэгдэхэд хөрөнгө оруулалт 210.0 сая, нефтийн бүтээгдэхүүн 22.0 сая ам.доллаар тус тус өссөн нь нөлөөлжээ. Дизель түлш 110.0 сая ам.доллар, удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүн 14.0 сая ам.доллаар тус тус нэмэгдсэн байна.

Нефтийн бүтээгдэхүүний импорт нь өнгөрсөн оны мөн үеэс 92.8 сая ам.доллаар өссөн байна. Үүнд нефтийн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн өсөлт нөлөөлжээ. Дизель түлшний импорт 370.0 сая ам.доллар, бензин 222.0 сая ам.доллаар нэмэгджээ. 2023 оны эхний улирлын байдлаар нефтийн бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 121.6 ам.дол/баррель болж, өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өсжээ.

График 12. Нефтийн бүтээгдэхүүний импорт, хилийн дундаж үнэ



ДӨРӨВ. МӨНГӨ САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

4.1. Мөнгөний нийлүүлэлт:

Мөнгөний нийлүүлэлт 2023 оны эхний улирлын эцэст 30,938.8 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 4,455.8 тэрбум төгрөг буюу 16.8 хувиар өссөн байна.

2022 оны мөн үеэс мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд гадаад валютын харилцах 2,324.2 тэрбум төгрөг буюу 83.7 хувиар, гадаад валютын хадгаламж 1,674.4 тэрбум төгрөг буюу 39.1 хувиар, М1 мөнгө 1,068.2 тэрбум төгрөг буюу 18.7 хувиар өссөн нь тус тус нөлөөлжээ. Харин төгрөгийн хадгаламж 4.5 хувь буюу 610.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 18. Мөнгөний нийлүүлэлтийн үзүүлэлтүүд

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний улирлын байдлаар			Өөрчлөлт (+/-)	
	2021	2022	2023	2023/2022	
				Дүн	Хувь
Мөнгөний нийлүүлэлт (М2)	25,433.0	26,483.0	30,938.8	4,455.8	16.8
Мөнгө М1	4,342.0	5,724.0	6,792.2	1,068.2	18.7
Төгрөгийн харилцах	3,603.0	4,996.6	6,025.0	1,028.4	20.6
Хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө	739.1	726.9	767.4	40.5	5.6
Бараг мөнгө	21,091.4	20,759.6	24,146.6	3,387.0	16.3
Төгрөгийн хадгаламж	14,367.3	13,701.7	13,091.0	(610.7)	-4.5
Валютын хадгаламж	4,447.1	4,280.6	5,955.0	1,674.4	39.1
Валютын харилцах	2,277.0	2,777.0	5,101.2	2,324.2	83.7
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	1,006.0	994.0	1,036.5	42.5	4.3

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны эхний улирлын байдлаар 23.2 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 1.1 их наяд төгрөг буюу 5.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 19. Зээлийн өрийн үлдэгдэл

/тэрбум төгрөг/

Үзүүлэлт	Эхний улирал			Өөрчлөлт (+/-)	
				2023/2022	
	2021	2022	2023	Дүн	Хувь
Зээлийн өрийн үлдэгдэл	17,636.4	22,086.6	23,230.8	1,144.2	5.2
-Хэвийн зээл	14,333.2	18,992.8	19,621.7	628.9	3.3
-Хугацаа хэтэрсэн зээл	1,282.5	969.3	1,383.6	414.3	42.7
-Чанаргүй зээл	2,020.7	2,124.5	2,225.6	101.1	4.8
Чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	11.5	9.6	9.6	-	-
Хугацаа хэтэрсэн зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь	7.3	4.4	6.0	-	-

Эх сурвалж: Монголбанк

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 54.0 хувь нь иргэдийнх, 44.8 хувь нь хувийн байгууллагынх, 0.6 хувь нь төрийн байгууллагынх, 0.6 хувь нь санхүүгийн болон бусад байгууллагынх байна. Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл 2023 оны эхний улирлын байдлаар 19,621.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 628.9 тэрбум төгрөг буюу 3.3 хувиар өссөн байна. Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 84.5 хувийг хэвийн зээл, 9.6 хувийг чанаргүй зээл, 6.0 хувийг хугацаа хэтэрсэн зээл эзэлж байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл: 2023 оны эхний улирлын байдлаар 1,383.6 тэрбум төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 414.3 тэрбум төгрөг буюу 42.7 хувиар өссөн байна. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.0 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.6 нэгж хувиар нэмэгджээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн хэмжээ: 2023 оны эхний улирлын байдлаар 2.2 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеэс 101.1 тэрбум төгрөг буюу 4.8 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 9.6 хувийг эзэлж, өнгөрсөн оны мөн үеийн түвшинд хэвээр байна.

Үнэт цаас: Үнэт цаасны арилжаагаар 2023 оны эхний улирлын байдлаар 87.0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Нийт арилжааны 60.3 хувь нь хувьцааны, 17.6 хувь нь хөрөнгө оруулалтын сангийн эрхийн, 13.7 хувь нь компанийн бондын 8.4 хувь нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байна. 2023 оны эхний улирлын байдлаар хөрөнгийн зах зээлийн үнэлгээний дүн 6,530.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 21.4 хувиар өссөн байна. Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2023 оны улирлын эцэст 38,538.8 нэгж болж, өмнөх оны мөн 515.4 нэгж буюу 1.4 хувиар өссөн байна.

Валютын ханш: 2023 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр төгрөгийн ам.доллартой харьцах нэрлэсэн сарын дундаж 3,524.9 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 623.2 төгрөгөөр /21.5 хувь/ суларсан байна. Мөн төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн сарын дундаж ханш 511.4 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 54.1 төгрөгөөр /11.8 хувь/ суларчээ.

График 13. АНУ-ын доллар ба БНХАУ-ын юанийн сарын дундаж ханш, 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар, төгрөгөөр




Хэрэглээний үнийн индекс:

Хэрэглээний үйлчилгээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 3 дугаар сард улсын хэмжээнд өнгөрсөн оны мөн үеэс 3.5 нэгж хувиар буурсан байна.

Дэлхийн ихэнх улс орнуудад үүсээд байсан тээвэрлэлтийн гацаа, нийлүүлэлтийн саатлууд сүүлийн саруудад намжиж, нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамт буурсан ч хүнсний бүтээгдэхүүн, эрчим хүч, үйлчилгээний үнэ өссөөр байгаа нь инфляц үргэлжлэн өсөхөд голлон нөлөөлж байна. Манай улсын хувьд нэг талаас гадаад орчны таагүй нөхцөл байдал үргэлжлэх, төлбөрийн тэнцлийн алдагдал тэлэх, зээл, санхүүжилтийн эх үүсвэр хумигдах зэрэг үйл явц эдийн засгийн идэвхжилд сөргөөр нөлөөлөх хандлагатай байгаа бол нөгөө талаас хүнсний үнэ өсөх, нийлүүлэлтийн буюу зардлын шалтгаантай инфляц удаан хугацаанд үргэлжлэх эрсдэл тулгарч байна.


График 14. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, сар бүрийн өөрчлөлт /хувиар/



4.2. Гадаад валютын албан нөөц:

Нийт албан нөөцийн хэмжээ 2023 оны эхний улирлын эцэст 3,438.5 сая ам.доллар болж өнгөрсөн оны мөн үеэс 119.9 сая ам.доллараар, 2022 оны эцэстэй харьцуулахад 38.9 сая ам.доллараар тус тус өссөн.

График 15. Нийт гадаад валютын албан нөөц /сая ам.доллараар/



Эх сурвалж: Монголбанк

Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2022 оны эцэст 3,399.6 сая ам.доллар болж импортын 4.6 сарын хэрэгцээг хангах түвшинд байсан. 2023 оны 3 дугаар сарын эцэст гадаад валютын албан нөөц 3,438.5 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 4 хувь буюу 119.9 сая ам.доллараар өссөн байна. 2023 он гарснаар импортын хэмжээ өссөн нь импортын хэрэгцээг хангах түвшнийг бууруулахад нөлөөлсөн байна.


Хүснэгт 20. Гадаад валютын албан нөөц ба импорт

/сая ам.доллар/

№	Үзүүлэлт	Эхний улирлын байдлаар				
		2019	2020	2021	2022	2023
1	Нийт импорт	1,285.7	1,161.6	1,522.7	1,690.7	1,939.6
2	Гадаад валютын нийт нөөц	3,660.4	4,094.2	4,774.6	3,318.6	3,438.5
3	Импортын хэрэгцээг хангах түвшин /сар/	8.5	10.6	9.4	5.9	5.3

Эх сурвалж: Монголбанк, Гаалийн ерөнхий газар

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ 2023 оны эхний улирлын дүнгээр 2.2 тонн болж, 2022 оны мөн үеэс 1.2 тонн буюу 34.9 хувиар буурч, сүүлийн 4 жилийн хамгийн бага дүн болж байна. Ялангуяа сүүлийн 4 жилд худалдан авсан алтны хэмжээ өндөр байсан бөгөөд эхний улиралд худалдан авсан алтны дундаж хэмжээ 3.4 тонн байна.

График 16. Алтны хэмжээ, 2012-2023 оноор /кг-аар/

Эх сурвалж: Монголбанк

4.3. Төлбөрийн тэнцэл:

Төлбөрийн тэнцэл нь урсгал тэнцэл, хөрөнгө ба санхүүгийн тэнцлээс бүрддэг. 2023 оны эхний улирлын гүйцэтгэлээр урсгал тэнцэл 61.3 сая ам.доллар, хөрөнгийн болон санхүүгийн тэнцэл 89.8 сая ам.долларын ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэл нийт дүнгээрээ 13.4 сая ам.долларын ашигтай гарахад нөлөөлжээ. Төлбөрийн тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 395.6 сая ам.доллараар сайжирч, ашигтай гарсан байна.

2023 оны эхний улирлын байдлаар урсгал тэнцэл 61.3 сая ам.долларын ашигтай гарахад бараа, үйлчилгээний худалдааны тэнцэл 452.1 сая ам.доллараар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

2023 оны эхний улирлын байдлаар хөрөнгийн тэнцэл 8.1 сая ам.долларын ашигтай, санхүүгийн тэнцэл 81.7 сая ам.долларын ашигтай тус тус гарсан байна. Өнгөрсөн оны мөн үед төлбөрийн тэнцэл 382.2 тэрбум ам.долларын алдагдалтай гарч байсан бол энэ оны 3 дугаар сард 13.4 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 21. Төлбөрийн тэнцэл, 2021-2023 оны байдлаар

/сая ам.доллар/

Үзүүлэлт	Эхний улирлын байдлаар			Өөрчлөлт	
	2021	2022	2023	Дүн	Хувь
I. Урсгал Тэнцэл	-126.3	-293.4	61.3	354.7	-120.9
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	-11.2	-217.8	234.3	452.1	-207.6
В. Анхдагч орлого	-134.9	-92.8	-185.4	-92.6	99.8
С. Хоёрдогч орлого	19.8	17.1	12.4	-4.7	-27.6
II. Хөрөнгийн тэнцэл	11.3	12.9	8.1	-4.9	-37.6
III. Санхүүгийн тэнцэл	-244.9	-99.2	81.7	180.9	-182.3
IV. Алдаа болон орхигдуулга	33.5	-200.9	25.7	226.6	-112.8
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	163.4	-382.2	13.4	395.6	-103.5

Эх сурвалж: Монголбанк

